



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 2147

Арвайхээр сум

Г Улсын баяр наадмаар эмнэлгийн  
тусламж үйлчилгээг зохицуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

1.Улсын баяр наадмаар эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй хангах зорилгоор 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 17-өдрийг хүртэлх хугацаанд ажиллах хариуцлагатай жижүүрүүдийн нэрсийг нэгдүгээр, эмнэлгийн тусламж үйлчилгээний болон дэмжих үйлчилгээг үзүүлэх багийн гишүүдийн нэрсийг хоёрдугаар, алс болон ойрын дуудлагад явах, тасагт дуудагдах эмч, мэргэжилтэн, жолооч нарын хуваарийг гуравдугаар хавсралтаар, аж ахуйн албаны хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Баярын өдрүүдэд үүсэж болзошгүй нийтийг хамарсан хордлого, осол гэмтэл, халдварт өвчний дэгдэлт, гал усны аюул үүсэх, эмнэлгийн тусламжийн бэлэн байдал алдагдах, жижүүр эмч, мэргэжилтэн, ажиллагсдын ажлын сахилга хариуцлага алдах эрсдэлээс урьдчилан сэргийлж, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эмнэлгийн тусламжийн аюулгүй байдал, эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаанд өдөрт 3 удаа хяналт тавьж, хариуцлагатай жижүүрийн тэмдэглэл үйлдэн, дараа өдрийн жижүүрт хүлээлгэн өгөх, шаардлагатай тохиолдолд БОЭТ-н удирдлага, Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүртэй холбогдон шуурхай мэдээллээр хангаж ажиллахыг хариуцлагатай жижүүр (Д.Баянмөнх) (Д.Болормаа) (Ц.Лувсандамдин) (Д.Аззаяа) (Б.Тунсагбямба) (Д.Цэцэгтуяа) нарт даалгасугай.

3.Үйлчлүүлэгчдэд үзүүлэх яаралтай тусламж, үер усны аюул, нарны болон хоолны хордлого, осол гэмтэл, болзошгүй халдварт өвчний үед авах арга хэмжээний бэлэн байдлыг ханган ороох боох материал, эм тариа, цус цусан бүтээгдэхүүн, машин техник, тоног төхөөрөмж, нэг удаагийн хэрэгслийг хангахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа) Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх) Яаралтай тусламжийн албаны эрхлэгч (Э.Мөнхцэцэг) Гэмтлийн тасгийн эрхлэгч (Б.Гангамөрөн) Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) Эм зүйн албаны дарга (Ц.Мөнгөнтуяа), ЦСТ-н эрхлэгч (Н.Долгорсүрэн) нарт үүрэг болгосугай.

4.Хүнд өвчтөн, жирэмсэн, төрсөн эх нярай, хүүхдэд үзүүлэх тусламжийг онцгой анхаарч эмнэлгийн тусламж үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, шаардлагатай өвчтөнд хамтарсан үзлэг зөвлөгөөнийг хугацаа алдалгүй хийх, тусламж үйлчилгээний эмнэл зүйн удирдамж, стандарт, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн чанартай гүйцэтгэж, аливаа таагүй тохиолдол,

алдаа зөрчлөөс сэргийлж жижүүрийг бүрэн хүлээлцэж, жижүүр эмчийн болон сувилахуйн мэдээг тухай бүр жижүүрийн ахлагчид цахимаар, шаардлагатай тохиолдолд Эмчилгээ эрхэлсэн дэд захирал болон сувилахуйн арга зүйчид биечлэн танилцуулж өвчтөний асуудлыг бүрэн шийдвэрлэж ажиллахыг жижүүрийн эмч сувилагч, мэргэжилтэнд үүрэг болгосугай.

5.Цагийн байдалтай уялдуулан машин техникийн бүрэн бүтэн байдал, шатахууныг хангалттай хэмжээгээр нөөцөлж авахыг нийт жолооч нарт, алсын болон төвийн дуудлагад гарч байгаа эмч, мэргэжилтэн, ажиллагсдын хувийн бэлтгэлийг хангуулж, яаралтай тусламжийг цаг алдалгүй, шуурхай үзүүлэхийг Яаралтай тусламжийн албаны эрхлэгч (Э.Мөнхцэцэг) Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх) нарт үүрэг болгосугай.

6.Баярын үеэр байгууллагын дотоод журамд заасан цагийн хуваарийг нарийн баримталж, удирдах ажилтнууд, клиник, албадын эрхлэгч, ахлагч нар, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд, ажиллагсад дуудсан тохиолдолд шуурхай ирж ажиллах, гар утсаа байнга нээлттэй байлгаж, хол явсан тохиолдолд холбоо барих утасны дугаарыг 103-т бүртгүүлэн, Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа)-д мэдэгдэж байхыг нийт ажиллагсадад үүрэг болгосугай.

7.Энэхүү тушаалын хэргэжилтэд хяналт тавьж жижүүрийн хугацаанд үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн, ажлын хариуцлага алдсан эмч ажиллагсдыг Удирдлагын зөвлөлд танилцуулан хариуцлага тооцож ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН